

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СБА-2024/09/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитор: Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг.  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН  
ТҮВШИНШИРЭЭ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Я.АНХТУЛГА  
ТАНАА

2024.03.25 № 273

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эмийн эргэлтийн сангийн эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг орон нутгийн хөрөнгөөс хасаж эзэмшигчдэд шилжүүлэх Аймгийн ИТХ-ын 2023 оны 08 тоот тогтоол гарсантай холбоотойгоор Эмийн эргэлтийн сангийн санхүүгийн тайланг ТТЗ-ын тайланд нэгтгээгүй байна.

### Аудитын гол асуудал

Орон нутгийн татварын болон татварын бус орлого 239.2 сая төгрөгөөр тасарсан бөгөөд хоёр жил дараалан тохиолдож буй цаг уурын хүнд нөхцөл байдлын улмаас малын тоо толгойн албан татварын орлого тасарсан нь татварын орлого тасрахад голлон нөлөөлсөн байна.

### Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 5 зорилт, 148 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 87.72 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	522,076.80	735,080.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	247,671.20	569,536.50
33	АВЛАГА	202,209.70	119,211.90
35	БАРАА МАТЕРИАЛ	72,196.00	46,332.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,217,317.70	1,411,367.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,217,317.70	1,411,367.20
39200	Биет хөрөнгө	1,155,212.20	1,333,610.30
39300	Биет бус хөрөнгө	62,105.50	77,757.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,739,394.50	2,146,448.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	5,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	5,000.00
41300	Өглөг	0	5,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,739,394.50	2,141,448.10
51	Засгийн газрын хувь оролцоо	1,739,394.50	2,141,448.10
51100	Засгийн газрын оруулсан капитал	355,537.90	353,521.90
51200	Хуримтлагдсан үр дүн	1,282,214.70	1,686,284.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	101,641.80	101,641.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,739,394.50	2,146,448.10

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,846,643.40	2,268,461.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	373,159.60	357,542.80
110	Орлогын албан татвар	225,034.10	274,610.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	225,034.10	274,610.00
113	Хөрөнгийн албан татвар	80,183.20	56,339.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	67,942.40	26,593.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	455,316.60	443,620.10
120	Нийтлэг татварын бус орлого	455,316.60	443,620.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,018,167.20	1,467,298.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,229,756.60	1,344,290.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,229,756.60	1,344,290.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,225,235.90	1,311,017.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,764.80	594,816.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,121.70	75,106.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	200,592.20	25,157.30
2104	Хангамж, бараа материалын зардал	56,614.60	61,310.80
2105	Нормативт зардал	3,325.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,921.90	2,574.30
2107	Томилолт, зочны зардал	6,940.00	11,187.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,275.00	273,994.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	320,680.70	266,770.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,004,520.60	33,272.90

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	616,886.80	924,170.60
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,399,990.20	512,279.20
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-5,783,103.40	411,891.30

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	7,555,939.40	0	7,555,939.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-33,351.90	0	-33,351.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,522,587.60	0	7,522,587.60
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-89.7	0	-89.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	-5,783,103.40	0	-5,783,103.40
10	2022 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	1,739,394.50	0	1,739,394.50
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,739,394.50	0	1,739,394.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,837.60	0	-9,837.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,729,556.80	0	1,729,556.80
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	411,891.30	0	411,891.30
20	2023 оны 12-р сарын 31- наарх үлдэгдэл	2,141,448.10	0	2,141,448.10

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,703,786.00	1,911,489.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	373,159.60	357,542.80
110	Орлогын албан татвар	225,034.10	274,610.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	225,034.10	274,610.00
113	Хөрөнгийн албан татвар	80,183.20	56,339.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	67,942.40	26,593.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,869.80	5,155.70
1181	Газрын төлбөр	607.6	557.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	63,465.00	20,880.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	312,459.20	87,428.00
120	Нийтлэг татварын бус орлого	312,459.20	87,428.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,018,167.20	1,466,518.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,182,254.50	1,163,227.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,182,254.50	1,163,227.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,173,393.10	1,129,569.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	445,817.90	593,845.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,902.60	76,078.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,875.10	28,795.90
2104	Хангамж, бараа материалын зардал	237,428.00	51,894.30
2105	Нормативт зардал	750	250
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,162.10	4,250.00
2107	Томилолт, зочны зардал	6,940.00	11,187.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,135.50	270,963.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,381.80	92,305.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,008,861.40	33,657.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	521,531.50	748,261.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	538,307.80	426,396.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	538,307.80	426,396.20
2200	Дотоод эх үүсвэрээр	538,307.80	426,396.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-538,307.80	-426,396.20
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-16,776.30	321,865.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	264,447.50	247,671.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	247,671.20	569,536.50

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,320,869.90	1,540,169.32	-43,844.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,332,333.30	1,119,781.17	-43,844.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,303,617.10	1,091,123.26	-43,844.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,583.20	593,485.03	0.00
210101	Үндсэн цалин	401,684.90	352,671.06	0.00
210102	Нэмэгдэл	146,192.30	152,904.66	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,769.00	13,949.00	0.00
210104	Урамшуулал	21,306.40	56,513.47	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,630.60	17,446.84	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,187.20	75,187.20	0.00
210201	Тэтгэврийн даатгал	51,113.90	51,113.90	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,042.10	6,042.10	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,833.80	4,833.80	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,208.60	1,208.60	0.00

210205	Эрүүл мэндийн даатгал	11,988.80	11,988.80	0.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>237,900.00</b>	<b>235,654.25</b>	<b>-43,796.43</b>
210301	Гэрэл, цахилгаан	57,200.00	60,278.54	-10,385.41
210302	Түлш, халаалт	143,900.00	158,092.70	-32,051.02
210303	Цэвэр, бохир ус	36,800.00	17,283.00	-1,360.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>59,225.70</b>	<b>47,817.40</b>	<b>0.00</b>
210401	Бичиг хэрэг	5,703.70	5,703.70	0.00
210402	Тээвэр, шатахуун	30,433.30	30,425.20	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,529.40	5,529.20	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,777.80	4,377.80	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,781.50	1,781.50	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>250.00</b>	<b>250.00</b>	<b>0.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	250.00	250.00	0.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,650.00</b>	<b>28,174.00</b>	<b>-1,048.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000.00	5,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250.00	250.00	0.00
210604	Урсгал засвар	24,400.00	22,924.00	-1,048.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,321.00</b>	<b>10,687.60</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт	12,321.00	10,687.60	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>108,899.00</b>	<b>31,167.70</b>	<b>1,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,000.00	27,107.25	1,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,027.00	1,008.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	522.00	476.27	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	900.00	475.15	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	650.00	422.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200.00	1,200.00	0.00
210807	Газрын төлбөр	500.00	379.03	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	100.00	100.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>175,601.00</b>	<b>68,700.09</b>	<b>0.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	169,601.00	62,737.49	1,452.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000.00	5,962.60	-1,452.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,716.20</b>	<b>28,657.91</b>	<b>0.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>28,716.20</b>	<b>28,657.91</b>	<b>0.00</b>
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	7,000.00	6,941.71	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,216.20	17,216.20	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,500.00	4,500.00	0.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>858,536.60</b>	<b>420,388.15</b>	<b>0.00</b>
220001	Барилга байгууламж	342,364.90	106,807.12	0.00
222001	Тоног төхөөрөмж	143,558.40	125,598.50	0.00
223001	Бусад хөрөнгө	372,613.30	187,982.53	0.00
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>130,000.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	130,000.00	0.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,320,869.90</b>	<b>1,819,953.38</b>	<b>-27,262.57</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>574,649.10</b>	<b>569,430.90</b>	<b>-553,478.79</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	574,649.10	569,430.90	624,285.60
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,533,333.30</b>	<b>1,169,435.87</b>	<b>526,216.22</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,533,333.30	1,169,435.87	1,095,647.12
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>212,887.50</b>	<b>81,086.62</b>	<b>0.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,697.30	75,886.62	0.00

350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,200.00	0.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	167,190.20	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	167,190.28	82,887.57
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	446,974.34	286,785.02

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>51,651.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>51,651.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>43,665.42</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>360.00</b>
210103	Унаа хоолны хөнгөлөлт	360.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>891.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	891.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,534.92</b>
210401	Бичиг хэрэг	50.00
210402	Тээвэр, шатахуун	4,114.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	360.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>500.00</b>
210702	Дотоод албан томилолт	500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,274.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,274.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>26,105.50</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,105.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,986.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,986.00</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,986.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>51,651.42</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>51,651.42</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,215.42
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,436.00

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар орлого, урсгал зардал, худалдан авалт, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой нийт 7 зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг цаашид давтан гаргахгүй байхад чиглэсэн зөвлөмж өгсөн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## **Орлоготой холбоотой асуудал**

### **5.3.1 Илрүүлэлт:**

- Төсвийн орлогыг төлөвлөхдөө тооцоо судалгааг хангалтгүй хийж, төсвийн орлого тасарсан, Төсвийн тухай хуульд заасан зарим нэр төрлийн орлогыг бүрэн дайчлаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Төсвийн орлогыг төлөвлөлт, орлогыг бүрэн дайчлах талаар бусад аймаг, сумдын сайн туршлагыг судлах, сайн туршлагыг төсвийн төлөвлөлтөд нэвтрүүлэх чиглэлээр үр нөлөөтэй арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх.

## **Худалдан авалттай холбоотой асуудал**

### **5.3.2 Илрүүлэлт:**

- Нүүрс тээврийн компаниар дамжуулан нүүрсийг худалдан авч байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Харьяа төсөвт байгууллагуудын нүүрсний худалдан авалтыг нүүрс тээврийн компаниар дамжуулахгүйгээр нүүрсний уурхайгаас худалдан авч байх.

### **5.3.3 Илрүүлэлт:**

- Барилгын ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээний зураг төсөв магадлалаар баталгаажаагүй байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29'.2.2-д "барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Барилгын ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээг магадлалаар баталгаажсан зураг төсвийг үндэслэн төсөвт тусгах, батлуулж, баталгаажсан зураг төслийг үндэслэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, захиалагчийн техник хяналт болон зохиогчийн хяналтыг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх.

### **5.3.4 Илрүүлэлт:**

- Барааны тендерийн хувьд зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэлгүйгээр тендер зарласан Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний хувьд тухайн тоног төхөөрөмжийн зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсний үндсэн дээр төсөвт тусгуулж, батлуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх.

### **5.3.5 Илрүүлэлт:**

- Харьяа төсөвт байгууллагууд цахим дэлгүүрт байгаа барааг цахим дэлгүүрээс худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

### **Өгсөн зөвлөмж:**

Цахим дэлгүүрт байгаа барааг тендерээр болон бусад этгээдээс худалдан авахгүй байх талаар харьяа төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад сургалт зохион байгуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.

#### 5.3.6 Илрүүлэлт:

- Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ болон холбогдох бусад хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тухайн сумын боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар зохион байгуулалт, байгаль орчин, жижиг дунд үйлдвэрлэл, шинэ ажлын байр, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хоршооллыг хөгжүүлэх зэрэг асуудлаар шалгуур үзүүлэлт, суурь ба хүрэх түвшнийг тодорхой тусгаж өгөөгүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд сумын боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар зохион байгуулалт, байгаль орчин, жижиг дунд үйлдвэрлэл, шинэ ажлын байр, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хоршооллыг хөгжүүлэх зэрэг асуудлаар шалгуур үзүүлэлт, суурь ба хүрэх түвшнийг тодорхой тусгаж өгөх талаар үр нөлөөтэй арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

